МЭДЭЭ · 2023 оны 12-р сарын 12

АРВАН НЭГДҮГЭЭР САРД ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ БУУРЧЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ
/2023.11.01-2023.12.01/

Нийт зөрчил 329.726 12.7%

Нийслэлд 234.853

Орон нутагт 94.873

Цагдаа	302.776
Гаалийн байгууллага	477
Татварын байгууллага	423
Гадаадын иргэн, харьяатын газар	624
Онцгой байдлын газар	31
Бусад	25.395

Зөрчлийн улмаас учирсан хохирол 3.314.064.000 төгрөг

Төлөгдсөн хохирол 2.227.231.000 төгрөг

Шийтгүүлсэн хүн 302.938

Хуулийн этгээд 742

77.9%

22.1%



16-18 нас 0.09%	36-45 нас 30.7%
18-25 нас 12%	46-55 нас 15.5%
26-35 нас 33.8%	56-аас дээш нас 7.1%

Буурсан зөрчил

Гаалийн тухай хууль зөрчих	17.968
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	817
Хүүхдийн эрхийг зөрчих	374
Татварын хууль зөрчих	96
Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	96
Хулгайлах зөрчил	63
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	273.100

Өссөн зөрчил

Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих 81



prokuror.mn

Улсын хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 329.726 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь аравдугаар сартай харьцуулахад 12.7 хувиар буурчээ.

Нийт зөрчлийн хэргийн 71.2 хувь нь Нийслэлд, 28.8 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бол Цагдаагийн байгууллага 92 хувийг, Гадаадын иргэн, харьяатын газар 0.18, Гаалийн байгууллага 0.14, Татварын байгууллага 0.12, Онцгой байдлын газар болон 0.01 хувийг шалгаж, бусад байгууллага 7.5 хувийг нь шалгаж, шийдвэрлэжээ.

Дээрх хугацаанд 742 хуулийн этгээд, 302.938 хүн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээснээс, 77.9 хувь нь эрэгтэй, 22.1 хувь нь эмэгтэй, 64.5 хувь нь 26-45 насныхан байна.

Зөрчлийн хэргийн улмаас хүн, хуулийн этгээд, төр, нийтийн ашиг сонирхолд 3.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, үүнээс 67.2 хувь буюу 2.2 тэрбум төгрөг нөхөн төлөгджээ.

Арван нэгдүгээр сард Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 1.6, Гаалийн тухай хууль зөрчих зөрчил 4.8, Хулгайлах зөрчил 7.4, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 13.6, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 17.8 хувиар тус тус буурсан бол Татварын хууль зөрчих зөрчил, Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх зөрчил тус бүр 25.6 хувиар буурсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Харин аравдугаар сартай харьцуулахад Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 9.5 хувиар өсжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1378